

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь даатгалын зуучлагчид тавигдах нөхцөл, шаардлагыг тодорхойлж, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын зуучлагчийн үйл ажиллагааг зохицуулж, хяналт тавих, зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Даатгалын зуучлалын тухай хууль тогтоомж

2.1.Даатгалын зуучлалын тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Даатгалын тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2.Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

2.3.Даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулах бөгөөд энэ хуульд зохицуулснаас бусад харилцааг холбогдох хуулиар зохицуулна.

3 дугаар зүйл.Хуулийн нэр томьёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн энэ хуулийн 3.2-т зааснаас бусад нэр томьёог Даатгалын тухай хуульд заасан утгаар ойлгоно.

3.2.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

3.2.1.“даатгалын зуучлалын үйл ажиллагаа” гэж даатгалын зуучлагч даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг борлуулах болон хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх үйл ажиллагааг;

3.2.2.“даатгалын зуучлагч” гэж даатгалын брокер, банк-зуучлагч, даатгалын төлөөлөгчийг;

3.2.3.“даатгалын брокер” гэж даатгуулагчийн хууль ёсны ашиг сонирхлыг

хамгаалах, даатгуулагчийг даатгагчтай холбож өгөх, талуудад мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх, үүнийхээ төлөө хөлс авах эрхтэй, даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий компанийг;

3.2.4.“банк-зуучлагч” гэж даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг банкны харилцагчдад зуучлан борлуулах, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх, үүнийхээ төлөө хөлс авах эрхтэй, даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл бүхий банкиг;

3.2.5.“даатгалын төлөөлөгч” гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх чиг үүрэг бүхий Хорооноос эрх олгосон этгээдийг;

3.2.6.“гадаадын даатгалын брокер” гэж гадаад улсад үүсгэн байгуулагдаж, Монгол Улсад даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авч үйл ажиллагаагаа хэрэгжүүлж буй даатгалын брокерыг;

3.2.7.“Даатгалын бүтээгдэхүүн” гэж тухайлсан даатгалын зүйлийг хамгаалах эрсдэл, нөхцөл, түүнд тохирсон хураамж бүхий Хороонд бүртгүүлсэн даатгалын гэрээг;

3.2.8.“Сэндбоксын зохицуулалтын орчин” гэж Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.12-т заасныг;

3.2.9.“хамтын даатгал” гэж Даатгалын тухай хуулийн 4.1.17-д заасан үйл ажиллагааг;

3.2.10.“холбогдох этгээд” гэж Даатгалын тухай хуулийн 4.1.19-д заасан этгээдийг.

3.3.Даатгалын байгууллагад ажиллаж буй ажилтан энэ хуулийн 3.2.7-д заасан даатгалын төлөөлөгчид хамаарахгүй.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ТӨРӨӨС ЗОХИЦУУЛАХ

4 дүгээр зүйл.Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

4.1.Даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь даатгалын зуучлалын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1.Даатгалын зуучлалын тухай хууль тогтоомжийг боловсронгуй болгох талаар санал боловсруулах;

4.1.2.Засгийн газрыг даатгалын зуучлалын бодлогын зөвлөгөөгөөр хангах;

4.1.3.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

5 дугаар зүйл.Даатгалын зуучлалын үйл ажиллагаанд Зохицуулах байгууллагын эрх үүрэг

5.1.Даатгалын зуучлалын үйл ажиллагааг зохицуулах, хянах эрхийг даатгалын асуудал хариуцсан Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/ хэрэгжүүлнэ.

5.2.Хороо дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

5.2.1.Даатгалын зуучлалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, хангуулах;

5.2.2.даатгалын зуучлагчийн үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар үүрэг, даалгавар өгөх, хариуцлага ногдуулах;

5.2.3.даатгалын брокер, банк-зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

5.2.4.даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгох, түдгэлзүүлэх, эрх хасах, сэргээх, нөхцөл, шаардлагыг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавих;

5.2.5.даатгалын брокер, банк-зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлгүй, даатгалын төлөөлөгчийн эрх аваагүй үйл ажиллагаа явуулсан этгээдэд арга хэмжээ авах;

5.2.6.Даатгалын зуучлалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах зорилгоор даатгалын зуучлагчийн дагаж мөрдөх хэм хэмжээ тогтоосон журам, заавар, аргачлал /цаашид “даатгалын журам” гэх/-ыг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих;

5.2.7.хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

5.3.Хороо энэ хуулийн 5.2.4-т заасан эрхийг нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр Даатгалын тухай хуулийн 68.1-д заасан этгээдэд шилжүүлж болно.

6 дугаар зүйл.Даатгалын журам

6.1.Даатгалын зуучлалын үйл ажиллагааг энэ хууль болон Хорооноос баталсан даатгалын журмаар зохицуулна.

6.2.Хороо даатгалын зуучлалын үйл ажиллагааг хянах, зохицуулах хүрээнд Даатгалын тухай хуулийн 14.2-т зааснаас гадна даатгалын дараах журмыг батална:

6.2.1.энэ хуульд заасан зөвшөөрлийг авах хүсэлт гаргах, түүнд тавигдах шаардлага, бүрдүүлэх баримт бичгийн загвар, маягт;

6.2.2.даатгалын зуучлагч, түүний үйл ажиллагаанд тавигдах нөхцөл шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт;

6.2.3.даатгалын зуучлагч энэ хуульд заасны дагуу санхүүгийн болон үйл ажиллагааны тайлан, мэдээ гаргаж, тайлагнах;

6.2.4.салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан үйл ажиллагаа явуулах гадаадын даатгалын брокерт тавигдах нөхцөл, шаардлага;

6.2.5.тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар;

6.2.6.хууль тогтоомжид заасан бусад.

6.3.Хороо даатгалын зуучлалын үйл ажиллагааг хөгжүүлэх, боловсронгуй болгох, даатгалын зуучлалын үйл ажиллагааг зохистой явуулах зорилгоор тусгайлан даатгалын журмыг өөрийн бүрэн эрхийн хүрээнд баталж болно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ЗУУЧЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ

7 дугаар зүйл.Даатгалын зуучлагчийн эрх, үүрэг

7.1.Даатгалын зуучлагч нь дараах эрх эдэлнэ:

7.1.1.даатгуулагчаас үнэн зөв, бүрэн, бодит мэдээлэл авах;

7.1.2.даатгагч болон даатгуулагчаас зуучлалын үйл ажиллагааны хөлс, шимтгэл авах;

7.1.3.хууль тогтоомжид заасан бусад эрх.

7.2.Даатгалын зуучлагч нь дараах үүрэг хүлээнэ:

7.2.1.даатгалын зуучлалын үйл ажиллагааг мэргэжлийн, нээлттэй, ёс зүйтэй гүйцэтгэх;

7.2.2.ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсэж болзошгүй нөхцөлд үйлчлүүлэгчид энэ талаар мэдэгдэх;

7.2.3.даатгалын гэрээ байгуулахаас өмнө болон даатгалын гэрээний хугацаанд даатгалын мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлчилгээ үзүүлэх;

7.2.4.даатгалын гэрээний нөхцөлийг даатгуулагчид энгийн ойлгомжтой түвшинд тайлбарлан өгөх, мэдээлэл авах нөхцөл боломжоор хангах;

7.2.5.даатгалын гэрээ болон хураамж төлсөн баримтыг даатгуулагчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр олгох;

7.2.6.даатгуулагч эсвэл даатгагчтай байгуулсан гэрээнд өөрөөр заагаагүй бол даатгалын хураамжийг хүлээн авсан даруйд даатгагчид шилжүүлэх;

7.2.7.даатгалын хураамж төлөх хугацаа, гэрээний сунгалтыг даатгуулагчид гэрээнд заасны дагуу тухай бүр мэдэгдэх;

7.2.8.даатгуулагчид даатгагчаа сонгох боломжийг олгож, эрхийг хязгаарлахгүй байх, даатгалын зуучлагч нь өөрийн хамтран ажилладаг даатгагчийн бүтээгдэхүүн үйлчилгээг тулгахгүй байх;

7.2.9.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

8 дугаар зүйл.Даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

8.1.Даатгалын брокерын үйл ажиллагааг Хорооноос зөвшөөрөл авсан компани эрхэлнэ.

8.2.Даатгалын брокерын үйл ажиллагаа нь дараах ангилалтай байна:

8.2.1.ердийн даатгалын брокер;

8.2.2.амьдралын даатгалын брокер;

8.2.3.давхар даатгалын брокер.

8.3.Даатгалын брокер нь энэ хуулийн 8.2-т заасан ангиллын дагуу даатгалын брокерын үйл ажиллагааг дангаар нь эрхэлнэ.

9 дүгээр зүйл.Банк-зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

9.1.Банк-зуучлагчийн үйл ажиллагааг Хорооноос зөвшөөрөл авсан банк эрхэлнэ.

9.2.Банк нь өөрийн банкны бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотойгоор даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучилна.

10 дугаар зүйл.Зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл гаргах

10.1.Энэ хуулийн 8.1 болон 9.1-д заасан үйл ажиллагаа эрхлэхийг хүссэн этгээд нь зөвшөөрөл хүссэн өргөдлөө Хороонд гаргана.

10.2.Өргөдлийг бичгээр, эсхүл Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 18.2-т заасан систем, албаны цахим шуудангаар дамжуулан цахим хэлбэрээр гаргах бөгөөд түүнд эрхлэх үйл ажиллагаа, ангиллыг зааж, Хорооноос баталсан загварын дагуу дараах баримт бичгийг хавсаргана:

10.2.1.Зөвшөөрөл хүссэн өргөдөл;

10.2.2.Компани байгуулах, даатгалын брокерын эсхүл банк-зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэр;

10.2.3.Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

10.2.4.Компанийн дүрэм болон шинэчилсэн дүрмийн төсөл;

10.2.5.Хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг хууль ёсны орлогоос бүрдсэнийг нотлох баримт;

10.2.6.Хувьцаа эзэмшигч бүрийн Хорооноос баталсан маягтын дагуу бөглөсөн хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт;

10.2.7.Компанийн эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт, иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбар, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн талаарх тодорхойлолт;

10.2.8.Хорооноос баталсан Тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан баримт бичиг;

10.2.9.Ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний хуулбар, техник тоног төхөөрөмж, программ хангамжийн талаарх танилцуулга, холбогдох материал;

10.2.10.3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө;

10.2.11.Жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан эсхүл эхлэлтийн тайлан;

10.2.12.Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан тухайн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн мэргэшлийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн мэргэжлийн боловсон хүчний Хорооноос баталсан маягтын дагуу бөглөсөн тодорхойлолт, тухайн даатгалын хэлбэрээр мэргэшсэнийг нотлох баримт;

10.2.13.Дотоод үйл ажиллагааны журмын төсөл;

10.2.14.Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-д заасан дотоод хяналтын хөтөлбөр, эрсдэлийн үнэлгээний тайлан, хариуцсан ажилтны тодорхойлолт.

10.3.Даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөлд энэ хуулийн 10.2.1-10.2.14-т заасан баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг хавсаргана:

10.3.1.Мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээний төсөл;

10.3.2.2-с доошгүй даатгалын компанитай хамтран ажиллах даатгалын зуучлалын гэрээний төсөл.

10.4.Банк-зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн өргөдөлд энэ хуулийн 10.2.1-10.2.14, 10.3.1-10.3.2-т заасан баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг хавсаргана:

10.4.1.Тус банкиг банк-зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэхэд татгалзахгүй тухай Монголбанкнаас ирүүлсэн баримт бичиг;

10.4.2.Банк-зуучлагчийн үйл ажиллагааг хариуцах 2-оос доошгүй орон тооны ажилтан бүхий тусгайлсан нэгжийг байгуулсан буюу томилсон тухай шийдвэрийн хуулбар, тухайн нэгжийн танилцуулга болон банкны бүтцийг харуулсан бүдүүвч зураг;

10.4.3.Хамтран ажиллах даатгагч бүр дээр даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбогдон гарах гүйлгээ хийгдэх тусдаа данс байхыг нотлох баримт.

10.5.Даатгалын зуучлагч нь Хороонд бүртгүүлсний үндсэн дээр эрх бүхий албан тушаалтныг томилно.

10.6.Хороо шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээлэл, баримт бичгийг зөвшөөрөл хүсэгчээс шаардаж болно.

11 дүгээр зүйл.Зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

11.1.Хороо дараах шаардлагыг хангасан зөвшөөрөл хүсэгчид зөвшөөрлийг олгох бөгөөд тухайн үйл ажиллагаа, ангиллаас хамааран нэмэлт шаардлага тавьж болно:

11.1.1.зөвшөөрөл олгосон нь энэ хуулийн 13 дугаар зүйлийг зөрчихөөргүй бол;

11.1.2.зөвшөөрөл хүсэгчийн эрх бүхий албан тушаалтан болон Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6.а-д заасан этгээд нь даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд бол;

11.1.3.зөвшөөрөл хүсэгч нь зөвшөөрлийг олгосны дараа энэ хууль болон даатгалын журмыг дагаж мөрдөх бүрэн боломжтой гэдэг нь нотлогдож байна гэж үзвэл;

11.1.4.тухайн даатгалын зуучлалын үйл ажиллагааг эрхлэхэд зөвшөөрөл хүсэгчийн удирдлага, зохион байгуулалт нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн бол;

11.1.5.тухайн даатгалын зуучлалын үйл ажиллагааг эрхлэхэд зөвшөөрөл хүсэгчийн санхүүгийн эх үүсвэр хууль ёсны орлогоос бүрдсэн, хангалттай гэж үзвэл;

11.1.6.зөвшөөрөл хүсэгчийн нэр нь даатгалын зуучлалын үйл ажиллагааг эрхэлнэ гэдгийг илэрхийлэхээр бол;

11.1.7.зөвшөөрөл олгох нь нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд сөрөг нөлөө үзүүлэхээргүй бол.

11.2.Хороо энэ хуулийн 8.1 болон 9.1-д заасан үйл ажиллагааны цар хүрээ, ангилал, төрлөөс хамааран зөвшөөрөлд тавигдах нөхцөл, шаардлагыг өөрчлөн тогтоож болно.

11.3.Зөвшөөрлийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр олгох бөгөөд түүнд Зөвшөөрлийн тухай хуулийн 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэдээллийг тусгана.

11.4.Энэ хуулийн 8.1 болон 9.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хугацаагүй олгох бөгөөд уг зөвшөөрөл нь энэ хуулийн 42, 43 дугаар зүйлд заасны дагуу түдгэлзүүлэх, хүчингүй болгох хүртэл хүчин төгөлдөр байна.

11.5.Хороо зөвшөөрөл хүсэгчийн зөвшөөрөл хүссэн өргөдлийг Зөвшөөрлийн тухай хуульд заасан хугацаанд шийдвэрлэнэ.

11.6.Хороо зөвшөөрөл хүсэгчид зөвшөөрөл олгохоос татгалзсан бол энэ тухай бичгээр, эсхүл энэ хуулийн 10.2-г заасан цахим хэлбэрээр мэдэгдэж, татгалзсан үндэслэлийг заана.

11.7.Хороо зөвшөөрөл олгосон, түдгэлзүүлсэн, хүчингүй болгосон тухай даатгалын журамд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

12 дугаар зүйл.Зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа эрхлэхийг хориглох

12.1.Хорооноос олгосон зөвшөөрөлгүйгээр аливаа этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт энэ хуулийн 8.1 болон 9.1-д заасан үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

12.2.Энэ хуулийн дагуу зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон этгээд энэ хуулийн 12.1-д заасанчлан үйл ажиллагаа явуулах эрхгүй.

12.3.Энэ хуулийн 8.1 болон 9.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохтой холбогдсон энэ хуульд зааснаас бусад харилцааг Зөвшөөрлийн тухай хуулиар зохицуулна.

13 дугаар зүйл.Зөвшөөрөл эзэмшигчид тавих хязгаарлалт

13.1.Энэ хуулийн 8.1 болон 9.1-д заасан зөвшөөрөлтэй компанийн ажилтан, эрх бүхий албан тушаалтан болон компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшиж буй этгээдэд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг олгохгүй.

13.2.Даатгагч, хөндлөнгийн хохирол үнэлэгч, тэдгээрийн хараат болон охин компани, даатгалын төлөөлөгчид даатгалын брокер, банк-зуучлагчийн зөвшөөрлийг олгохгүй.

13.3.Даатгагчийн ажилтан, эрх бүхий албан тушаалтанд даатгалын брокер, банк-зуучлагчийн зөвшөөрөл, төлөөлөгчийн эрхийг олгохгүй бөгөөд уг этгээд нь даатгалын брокер, банк-зуучлагчийн зөвшөөрөл эзэмшигчийн ажилтан буюу эрх бүхий албан тушаалтан байж болохгүй.

13.4.Энэ хуулийн 8.1 болон 9.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг давхардуулан олгохгүй.

14 дүгээр зүйл.Гадаадын даатгалын брокерын үйл ажиллагаа

14.1.Гадаадын даатгалын брокер нь гагцхүү Хорооноос бичгээр, эсхүл цахим хэлбэрээр авсан зөвшөөрлийн үндсэн дээр Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын брокерын үйл ажиллагаа явуулах эрхтэй.

14.2.Гадаадын даатгалын брокер нь энэ хуулийн 14.1-д заасны дагуу Хорооноос бичгээр, эсхүл цахим хэлбэрээр зөвшөөрөл аваагүй тохиолдолд аливаа этгээд Монгол Улсад гадаадын даатгалын брокерыг төлөөлж дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

14.2.1.даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх;
14.2.2.даатгалын брокерын үйл ажиллагаа явуулах зорилгоор сурталчилгаа, ухуулга хийх, эсхүл ийм зорилгоор албан газар нээх, ажиллуулах;

14.2.3.салбар, төлөөлөгчийн газар нээх, ажиллуулах.

14.3.Гадаадын даатгалын брокерын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахыг хүсэж буй этгээд нь өргөдлөө Хороонд бичгээр, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан цахим хэлбэрээр гаргах бөгөөд өргөдөлд дараах баримт бичгийг монгол, англи хэлээр орчуулан хавсаргана:

14.3.1.Салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл хүссэн хүсэлт;

14.3.2.Төлөөлөн удирдах зөвлөл, эсхүл түүнтэй адилтгах эрх бүхий удирдлагаас Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газар нээх тухай шийдвэр;

14.3.3.Харьяалах улсын эрх бүхий төрийн байгууллагын Монгол Улсын нутаг дэвсгэрт даатгалын үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрсөн шийдвэр, эсхүл түүнтэй адилтгах баримт бичиг;

14.3.4.Тухайн салбар, төлөөлөгчийн газрыг нээх гэж буй этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө /дүрмийн сан/-ийн хэмжээ, бүтэц болон үйл ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээлэл бүхий нотлох баримт бичиг;

14.3.5.нээн ажиллуулах гэж буй салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг зохицуулсан журам;

14.3.6.Монгол Улсын аль нэг банкны дансанд даатгалын журамд заасан даатгалын баталгаа хөрөнгө байршуулсныг нотлох баримт бичиг;

14.3.7.Өөрийн харьяалагдах улсаас бусад улс оронд даатгалын салбар, төлөөлөгчийн газар байгуулж, үйл ажиллагаагаа 2-оос доошгүй жил тогтвортой явуулсныг нотлох баримт бичиг;

14.3.8. Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газраа нээх зөвшөөрөл хүсэгч гадаадын даатгалын брокерын өөрийн хөрөнгө нь даатгалын журамд заасан шаардлагыг хангасныг нотлох баримт бичиг;

14.3.9.Даатгалын журамд дурдсан зөвлөмжийн дагуу боловсруулсан салбарын үйл ажиллагааны бизнес төлөвлөгөө;

14.3.10.Даатгалын журамд заасан маягтын дагуу гаргасан гүйцэтгэх удирдлага болон бусад боловсон хүчний тодорхойлолт;

14.3.11.Салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагаанд ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн жагсаалт, ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний хуулбар;

14.3.12.Зөвшөөрөл хүсэж буй этгээдийн сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлангийн хуулбар;

14.3.13.Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт.

14.4.Хороо шаардлагатай гэж үзвэл мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдсон эсэх тухай болон компанийн эрх бүхий албан тушаалтны ял шийтгэлтэй эсэх талаар цагдаагийн байгууллагын тодорхойлолт, хэрэв гадаадын иргэн бол уг иргэний харьяалалтай улсын эрх бүхий байгууллагын тодорхойлолтыг шаардаж болно.

14.5.Хороо энэ хуулийн 14.1-д заасан зөвшөөрлийг хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэхдээ нэмэлт мэдээлэл, баримт бичгийг зөвшөөрөл хүсэгчээс шаардаж болно.

14.6.Энэ хуулийн 14.1-д заасан зөвшөөрөл олгохдоо Хороо тодорхой нөхцөл, шаардлага тавьж болох бөгөөд эдгээр нөхцөл, шаардлагыг өөрчлөн тогтоож болно.

15 дугаар зүйл.Даатгалын брокер хамтын даатгалын үйл ажиллагаанд оролцох

15.1.Даатгалын брокер нь Даатгалын тухай хуулийн 4.1.17-д заасан хамтын даатгалын үйл ажиллагааг зохион байгуулахад оролцож болно.

15.2.Даатгалын брокер нь хамтын даатгалын үйл ажиллагааг зохион байгуулах тохиолдолд тухайн даатгалын брокерын зохион байгуулалтын энэхүү үүрэг нь хамтын даатгалын гэрээ дуусгавар болсноор зогсоно.

16 дугаар зүйл.Технологид суурилсан үйл ажиллагаа эрхлэх

16.1.Аливаа этгээд санхүүгийн үйлчилгээнд шинээр нэвтэрч буй технологид суурилсан шинэлэг бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Сэндбоксын зохицуулалтын орчинд туршсаны үндсэн дээр даатгалын зах зээлд нэвтрүүлж, үйл ажиллагаа эрхэлж болно.

16.2.Энэ зүйлийн 16.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх, түүнд хяналт тавих зорилгоор Хороо журам баталж болно.

17 дугаар зүйл.Засаглалын тогтолцоо

17.1.Энэ хуулийн 8.1 болон 9.1-д заасан хуулийн этгээд нь даатгалын зуучлалын үйл ажиллагааг найдвартай, оновчтой удирдлагаар хангаж, бизнесийн үйл ажиллагааны шинж чанар, цар хүрээ, цогц байдалд нийцэх үр дүнтэй засаглалын тогтолцоог бий болгож, мөрдөж ажиллана.

18 дугаар зүйл.Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааны эрхлэх

18.1.Хороо даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг 18.3-т заасан этгээдэд олгоно.

18.2.Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа нь дараах төрөлтэй байна:

18.2.1.нэг даатгагчийг төлөөлөх;

18.2.2.хэд хэдэн даатгагчийг төлөөлөх.

18.3.Энэ хуулийн 18.2.1-д заасан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг иргэнд, 18.2.2-т заасан даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрхийг хуулийн этгээдэд олгоно.

19 дүгээр зүйл.Эрх хүсэх тухай өргөдөл гаргах

19.1.Даатгагчаас даатгалын төлөөлөгчөөр томилогдсон этгээд нь энэ хуулийн 18.1-д заасан эрх хүссэн өргөдлөө даатгагчаар дамжуулан Хороонд гаргана.

19.2.Өргөдлийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр гаргах бөгөөд түүнд эрхлэх үйл ажиллагаа, төрлийг зааж, Хорооноос баталсан загварын дагуу дараах баримт бичгийг хавсаргана:

19.2.1.Даатгагчтай хамтран ажиллах гэрээний төсөл;

19.2.2.Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн даатгалын төлөөлөгчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт.

19.3.Зөвшөөрөл хүсэгч нь 18.2.1-т заасан эрхийг авах бол 19.2.1 болон 19.2.2-т заасан баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг хавсаргана:

19.3.1.Нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар;

19.3.2.Зөвшөөрөл хүсэгчийн иргэний цахим үнэмлэх.

19.4.Зөвшөөрөл хүсэгч нь 18.2.2-т заасан эрхийг авах бол 19.2.1 болон 19.2.2-т заасан баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг хавсаргана:

19.4.1.Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;

19.4.2.Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар;

19.4.3.Хуулийн этгээдийн дүрмийн хуулбар, шинэчилсэн дүрмийн төсөл.

19.5.Хороо шаардлагатай гэж үзсэн нэмэлт мэдээлэл, баримт бичгийг зөвшөөрөл хүсэгчээс шаардаж болно.

20 дугаар зүйл.Эрх олгох, олгохоос татгалзах

20.1.Хороо дараах шаардлагыг хангасан зөвшөөрөл хүсэгчид эрх олгох бөгөөд нэмэлт шаардлага тавьж болно:

20.1.1.эрх олгосон нь энэ хуулийн 13.2, 13.3-т заасныг зөрчихөөргүй бол;

20.1.2.зөвшөөрөл хүсэгч нь даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тохиромжтой этгээд бол;

20.1.3.зөвшөөрөл хүсэгч энэ хууль болон даатгалын журмыг дагаж мөрдөх бүрэн боломжтой гэдэг нь нотлогдож байна гэж үзвэл.

20.2.Хороо зөвшөөрөл хүсэгчид даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх олгосон тухай бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:

- 20.2.1.эрх олгосон иргэний овог, нэр, хуулийн этгээд бол компанийн нэр;
- 20.2.2.эрх олгосон этгээдийн регистрийн дугаар;
- 20.2.3.даатгалын төлөөлөл хэрэгжүүлэх даатгагчийн нэрс;
- 20.2.4.эрхлэх үйл ажиллагаанд тавих нөхцөл, шаардлага;
- 20.2.5.эрхийн дугаар, эрх олгосон огноо.

20.3.Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх нь энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасны дагуу эрх хасах хүртэл хүчин төгөлдөр байна.

20.4.Хороо зөвшөөрөл хүсэгчид эрх олгохоос татгалзсан бол энэ тухай бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэж, татгалзсан үндэслэлийг заана.

20.5.Хороо хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор эрх олгох эсэхийг шийдвэрлэнэ.

20.6.Хороо даатгалын төлөөлөгчийн эрх авсан этгээдийг нийтэд ил тод байршуулна.

21 дүгээр зүйл.Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглох

21.1.Хорооноос эрх аваагүй аливаа этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

21.2.Энэ хуулийн дагуу эрх хасагдсан этгээд даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа явуулах эрхгүй.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХӨРӨНГӨ, ХУВЬЦАА

22 дугаар зүйл.Хувь нийлүүлсэн хөрөнгө

22.1.Энэ хуулийн 8.1 болон 18.2.2-т заасан хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө нь хувьцаа эзэмшигчдийн хууль ёсны үйл ажиллагааны орлогоос бүрдүүлсэн мөнгөн хөрөнгөөс бүрдэнэ.

22.2.Энэ хуулийн 22.1-д заасан хувь нийлүүлсэн хөрөнгийг зээлийн хөрөнгөөр бүрдүүлэхийг хориглоно.

22.3.Хувь нийлүүлсэн хөрөнгө энэ хуулийн 22.1-д заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд энэ тухай Хороонд нэн даруй бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

22.4.Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт орох тухай бүрд Хороонд мэдэгдэж, бүртгүүлнэ.

23 дугаар зүйл.Хувьцаа шилжүүлэхэд тавих хяналт

23.1.Хувьцаа шилжүүлэхэд дараах шаардлага тавигдана:

23.1.1.хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогын эх үүсвэрээс бүрдсэн байх;

23.1.2.хувьцаа эзэмшигч этгээд нь Хорооноос баталсан тохиромжтой этгээдийг тодорхойлох шалгуурыг хангасан байна.

ТАВДУГААР БҮЛЭГ САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛ, АУДИТ

24 дүгээр зүйл.Нягтлан бодох бүртгэлийн үзүүлэлт болон санхүүгийн тайлан

24.1.Дараах этгээд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон даатгалын журамд заасны дагуу нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргана:

24.1.1.энэ хуулийн 8.1-д заасан даатгалын брокер;

24.1.2.энэ хуулийн 9.1-д заасан банк-зуучлагч;

24.1.3.энэ хуулийн 18.2.2-т заасан хэд хэдэн даатгагчийг төлөөлөх даатгалын төлөөлөгч.

24.2.Даатгалын журамд өөрөөр заагаагүй бол Хороо энэ хуулийн 24.1-д заасан этгээдийн нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг тогтоож болно.

24.3.Санхүүгийн тайлан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8.1-д болон энэ хуулийн 24.2-т заасны дагуу Хорооноос тогтоосон баримт бичгээс бүрдэнэ.

24.4.Нягтлан бодох бүртгэлийн баримт бичгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлд заасан хугацаагаар хадгалах бөгөөд хадгалах газрын хаягийг Хороонд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэнэ.

25 дугаар зүйл.Нягтлан бодох бүртгэлийн стандарт мөрдөх

25.1.Энэ хуулийн 24.1-д заасан этгээд нь нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг дагаж мөрдөнө.

26 дугаар зүйл.Жил бүрийн санхүүгийн тайлан

26.1.Энэ хуулийн 24.1-д заасан этгээд нь жилийн эцсийн санхүүгийн тайлан болон даатгалын журамд заасан бусад бичиг баримтын хамт дараа оны эхний сард багтаан Хороонд ирүүлнэ.

26.2.Энэ хуулийн 8.1-д заасан даатгалын брокер, 18.2.2-т заасан хэд хэдэн даатгагчийг төлөөлөх даатгалын төлөөлөгч нь аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлангаа дараа оны нэгдүгээр улиралд багтаан Хороонд ирүүлнэ.

26.3.Энэ хуулийн 26.1, 26.2-т заасан тайланг Хороонд ирүүлээгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

27 дугаар зүйл.Улирал тутмын тайлан

27.1.Энэ хуулийн 24.1-д заасан этгээд нь улирал тутмын санхүүгийн тайлангаа дараа улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор Хороонд ирүүлнэ.

27.2.Даатгалын журамд заасан баримт бичгийг ирүүлээгүй тохиолдолд санхүүгийн тайланг өгөөгүйд тооцно.

28 дугаар зүйл.Даатгалын байгууллагад аудит хийх үйл ажиллагаа

28.1.Энэ хуулийн 8.1-д заасан даатгалын брокер, 18.2.2-т заасан хэд хэдэн даатгагчийг төлөөлөх даатгалын төлөөлөгч нь санхүүгийн тайландаа заавал аудит хийлгэх бөгөөд санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдтэй холбогдох харилцааг Даатгалын тухай хуулиар зохицуулна.

28.2.Аудит хийх хуулийн этгээд нь өөрийн баталгаажуулсан дэлгэрэнгүй тайлан, түүний талаарх эцсийн дүгнэлтийг даатгалын журамд заасны дагуу энэ хуулийн 8.1-д заасан даатгалын брокер, 18.2.2-т заасан хэд хэдэн даатгагчийг төлөөлөх даатгалын төлөөлөгчид хүргүүлнэ.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ТҮҮНД ТАВИГДАХ ХЯЗГААРЛАЛТ

29 дүгээр зүйл.Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа

29.1.Даатгалын зуучлагч Даатгалын тухай хуулийн дагуу зөвшөөрөл аваагүй этгээдтэй хамтран үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

29.2.Энэ хуулийн 29.1-д заасан даатгалын зуучлагч гадаадын даатгагчтай хамтран ажиллахад хамаарахгүй.

29.3.Даатгалын төлөөлөгч нь иргэнтэй байгуулах даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг зуучилна.

29.4.Даатгалын төлөөлөгч нь хуулийн этгээдтэй даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ зуучлан борлуулах тохиолдолд Хороо нэмэлт шаардлага тавих бөгөөд үүнтэй холбоотой харилцааг даатгалын журмаар зохицуулна.

29.5.Даатгалын тухай хуулийн 7.1-д заасан заавал даатгалын хувьд энэ хуулийн 29.3 дахь заалт хамаарахгүй.

29.6.Энэ хуулийн 18.2.1-д заасан нэг даатгагчийг төлөөлөх даатгалын төлөөлөгчийн хувьд энэ хуулийн 7.2.8 дахь заалт хамаарахгүй.

30 дугаар зүйл.Даатгалын зуучлагчийн төлбөр, хөлс, хураамж

30.1.Даатгалын зуучлагч доор дурдсанаас бусад тохиолдолд даатгагчийн байгуулсан гэрээний дагуу төлөгдөж буй хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг хориглоно:

30.1.1.даатгалын хураамжийг хүлээн авах, эзэмших, түүнтэй холбоотой хэлцэл хийхийг даатгалын зуучлагчийн үйлчлүүлэгч зөвшөөрсөн;

30.1.2.Хорооноос эрх олгосон.

30.2.Хороо даатгалын ангилал, хэлбэр, төрлөөс хамааран даатгагчаас даатгалын зуучлагчид олгох борлуулалтын хөлс, орлогын шимтгэлийн хувь хэмжээ, хязгаарыг тогтоож болно.

30.3.Даатгалын зуучлагч нь зөвхөн гуравдагч этгээдийн даатгалын гэрээг борлуулах, зуучлах бөгөөд өөрийн ашиг сонирхлыг даатгуулсан бол зуучлалын хөлс, шагнал авахыг хориглоно.

31 дүгээр зүйл.Мэдээллийг өөрчлөх

31.1.Энэ хуулийн 8.1 болон 9.1-д заасан үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүсэж байгаа этгээд, эсхүл даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх эрх хүсэж байгаа этгээд энэ хууль, даатгалын журамд заасны дагуу Хороонд гаргаж буй аливаа зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хэлэлцэн шийдвэрлэхээс өмнө Хороонд ирүүлсэн мэдээлэл, баримтад өөрчлөлт орвол зөвшөөрөл хүссэн этгээд энэ тухай нэн даруй бичгээр, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан цахим хэлбэрээр мэдэгдэх үүрэгтэй.

ДОЛООДУГААР БҮЛЭГ ЗАХ ЗЭЭЛИЙН ЗОХИСТОЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

32 дугаар зүйл.Зах зээлийн зохистой үйл ажиллагаа

32.1.Хороо даатгалын салбарын дагаж мөрдвөл зохих зах зээлийн зохистой үйл ажиллагааны журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд даатгалын зуучлалын үйл ажиллагаанд оролцогч болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан түүнийг дагаж мөрдөх үүрэгтэй.

33 дугаар зүйл.Төөрөгдүүлсэн зар сурталчилгаа

33.1.Даатгалын зуучлагч нь төөрөгдүүлсэн, эсхүл худал мэдээлэл агуулсан зар сурталчилгаа, мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад бичиг баримт гаргах, тараах, тараахыг зөвшөөрөхийг хориглоно.

33.2.Даатгалын зуучлагч болон түүний нэрийн өмнөөс гаргасан мэдээлэл, товхимол болон түүнтэй адилтгах бусад баримт бичиг нь төөрөгдүүлсэн буюу худал мэдээлэл агуулсан, эсхүл нийтийн ашиг сонирхолд харшилсан гэж үзвэл Хороо тухайн баримт бичгийг гаргахыг хориглох, няцаахыг даалгах, эсхүл шаардлагатай гэж үзсэн өөрчлөлт, залруулга хийж гаргахыг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр даалгана.

НАЙМДУГААР БҮЛЭГ ХЯНАЛТ ШАЛГАЛТ, МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАХ, ТАЙЛАГНАХ

34 дүгээр зүйл. Үйл ажиллагааны хяналт шалгалт

34.1. Хороо энэ хуулийн дагуу даатгалын зуучлагч болон тэдгээрийн холбогдох этгээдийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ.

34.2. Хороо энэ хуулийн 34.1-д заасан хяналт шалгалтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг даатгалын журмаар зохицуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

34.3. Энэ хуулийн 34.1-д заасан хяналт, шалгалтыг Хорооны даргын баталсан шалгалтын удирдамжийн дагуу хэрэгжүүлэх ба удирдамжийг хяналт, шалгалтад хамрагдах этгээдэд урьдчилан танилцуулна.

34.4. Хороо шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааны шалгалтыг хэрэгжүүлэхдээ тохирох мэргэшсэн, дадлага туршлага, мэргэжил бүхий этгээдийг татан оролцуулж болно.

34.5. Хороо энэ хуулийн 34.1-д заасан хяналт, шалгалтад хамрагдах этгээдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлж болно:

34.5.1. үйл ажиллагаа, удирдлага, зохион байгуулалт, холбогдох баримт бичгийг цаасаар болон цахим хэлбэрээр шалгах;

34.5.2. шалгалтад хамрагдах этгээдийн хяналт болон эзэмшилд буй эд хөрөнгө, мөнгөн хөрөнгийн байршлыг хянаж шалгах;

34.5.3. нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон бусад баримт бичгийг хуулбарлан авч хянаж шалгах;

34.5.4. үйл ажиллагаанд ашиглаж буй программ хангамж, аливаа техник технологийн талаар болон түүнд агуулагдах мэдээ, мэдээлэл, холбогдох материалыг шалгах;

34.5.5. цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан шаардлагатай гэж үзсэн бусад мэдээлэл.

34.6. Хороо энэ хуульд заасан хяналт шалгалтын зарим чиг үүргээ тухайн чиглэлээр мэргэшсэн этгээдтэй гэрээ байгуулсны үндсэн дээр гүйцэтгүүлж болно.

35 дугаар зүйл. Нэгдсэн хяналт шалгалт

35.1. Хороо нь энэ хуулийн 34.1-д заасан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэхдээ шаардлагатай гэж үзвэл холбогдох төрийн байгууллагатай хамтран нэгдсэн хяналт шалгалтыг хийх бөгөөд түүнд хамрагдах хуулийн этгээдийн санхүүгийн тайланг нэгдсэн байдлаар гаргаж үнэлэлт, дүгнэлт өгнө.

35.2. Энэ хуулийн 35.1-д заасан нэгдсэн хяналт шалгалтад зөвшөөрөл эзэмшигчийн холбогдох этгээдийг хамруулах, тэдгээрийн санхүүгийн тайлан,

холбогдох бусад мэдээллийг гаргаж тайлагнах, хяналт шалгалт хийх харилцааг холбогдох төрийн байгууллагатай хамтран баталсан удирдамжийн дагуу зохицуулна.

35.3.Холбогдох этгээд нь өөр улсад бүртгэгдсэн буюу байршдаг бол Хороо тухайн орны эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох болон бусад хэлбэрээр хамтран ажиллаж нэгдсэн хяналт, шалгалтыг хэрэгжүүлж болно.

35.4.Хорооноос шаардсан мэдээллийг тогтоосон хугацаанд тухайн холбогдох этгээд өөрөө, эсхүл зөвшөөрөл эзэмшигчээр дамжуулан гаргаж өгнө.

36 дугаар зүйл.Хяналт, шалгалттай холбоотой этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, ажилтны үүрэг

36.1.Энэ хуулийн 34.1-д заасан хяналт, шалгалтад хамрагдах этгээд шалгалт хийхтэй холбоотой дараах үүрэг хүлээнэ:

36.1.1.хяналт шалгалтын үйл ажиллагааг бие даасан, хараат бусаар явуулах нөхцөлөөр хангах;

36.1.2.өөрийн байранд нэвтрэх, эд хөрөнгийг шалгах боломжоор хангах;

36.1.3.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлан болон холбогдох бусад баримт бичгийг гаргаж өгөх;

36.1.4.шаардлагатай мэдээ, мэдээлэл, тайлбарыг баримтаар болон цахим хэлбэрээр саадгүй, бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх;

36.1.5.үйл ажиллагаандаа ашиглаж буй программ хангамж, аливаа техник технологийн талаар болон түүнд агуулагдах мэдээ, мэдээлэл, холбогдох материалыг бэлтгэж өгөх;

36.1.6.шаардлагатай баримт бичгийг бусад этгээдээс авч Хороонд өгөх;

36.1.7.Хороо, түүний хянан шалгагчийн хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд шаардсан баримт, мэдээ мэдээлэл байхгүй бол хяналт, шалгалтад хамрагдах этгээд энэ тухайгаа бичгээр, эсхүл цахим хэлбэрээр мэдэгдэх;

36.1.8.шалгалт хийж буй этгээдийн нэр хүндэд халдахгүй байх, хууль бус нотолгоогүй мэдээ мэдээллийг аливаа хэлбэрээр тараахгүй байх;

36.1.9.хууль тогтоомжид заасан бусад үүрэг.

36.2.Хороо энэ хуулийн 34.1-д заасан хяналт, шалгалтыг хэрэгжүүлэх явцад шаардлагатай мэдээлэл, тайлбарыг шалгалтад хамрагдах этгээдийн эрх бүхий албан тушаалтан болон ажилтнаас аливаа хэлбэрээр авч болно.

37 дугаар зүйл.Шалгалтын тайлан

37.1.Хороо нь үйл ажиллагааны шалгалт дууссанаас хойш ажлын 45 өдрийн дотор шалгалтын товч тайланг холбогдох этгээдэд хүргүүлнэ.

37.2.Шалгалтын тайланд дараах зүйлийг тусгана:

37.2.1.шалгалтад хамрагдсан этгээдийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт болон шаардлагатай гэж үзсэн бусад асуудлын талаарх зөвлөмж, дүгнэлт;

37.2.2.тайлантай холбогдуулан шалгалтад хамрагдсан этгээдээс хариу шаардаж байгаа эсэх, хариу шаардаагүй бол тайланд онцгойлон үзэж буй асуудлын талаар.

37.3.Шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан, эсхүл албан шаардлага өгсөн бол шалгалтад хамрагдсан этгээд тайлан, албан шаардлагыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 өдрийн дотор, эсхүл тэдгээрт тусгайлан заасан хугацаанд Хороонд хариу мэдэгдэх үүрэгтэй.

38 дугаар зүйл.Хорооны мэдээлэл цуглуулах эрх

38.1.Хороо энэ хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл гадаадын зохицуулах байгууллагын тавьсан хүсэлтийн дагуу энэ хуулийн 38.2-т заасан этгээдээс тодорхой төрлийн буюу тусгайлан заасан мэдээлэл, баримт бичгийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр шаардаж болно.

38.2.Энэ хуулийн 38.1-д заасан мэдэгдлийг холбогдох этгээд болон түүнтэй хамаарал бүхий этгээд эсхүл, мэдэгдэлтэй холбоотой мэдээлэл, баримт бичиг байгаа гэж үзсэн этгээдэд өгөх бөгөөд уг мэдэгдэлд мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөх болон үйлдэх хугацаа, газрыг заана.

38.3.Энэ хуулийн 38.2-т заасан “хамаарал бүхий этгээд”-ийг Хорооноос баталсан даатгалын журмаар тодорхойлж, нэгдсэн бүртгэл хөтөлнө.

38.4.Хороо энэ хуулийн 38.1-д заасан эрхээ хэрэгжүүлэхдээ дараах шаардлагыг тавьж болно:

38.4.1.тогтоосон хэлбэр, загвараар мэдээлэл бэлтгэж ирүүлэхийг;

38.4.2.мэдээлэл, баримт бичгээ баталгаажуулахыг;

38.4.3.мэдээлэл, баримт бичигтэй холбогдуулан тайлбар гаргахыг.

38.5.Хороо энэ хуульд заасны дагуу мэдээлэл цуглуулахдаа холбогдох баримт бичгийг түүвэрлэн буюу хуулбарлан авч болно.

38.6.Хорооноос энэ хуулийн 38.1-д заасны дагуу мэдээлэл, баримт бичгээр хангахыг даалгасан мэдэгдлийг хүлээн авсан этгээд нь өөрийн үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдалтай холбоотой бүхий л баримт материал, тайлан бүртгэл, мэдээ, мэдээлэл, холбогдох бусад баримт бичгийг Хорооны шаардсанаар гарган өгөх үүрэгтэй.

39 дүгээр зүйл.Гадаадын зохицуулах байгууллагад туслалцаа үзүүлэх

39.1.Гадаадын зохицуулах байгууллага өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан туслалцаа үзүүлэхийг бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүссэн

тохиолдолд Хороо энэ хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу холбогдох мэдээлэл, баримт бичгээр хангаж болно.

39.2.Гадаадын зохицуулах байгууллагыг мэдээлэл, баримт бичгээр хангах эсэхийг шийдвэрлэхдээ дараах асуудлыг анхаарна:

39.2.1.гадаадын зохицуулах байгууллага нь уг асуудалтай төстэй асуудлаар харилцан туслалцаа үзүүлж байсан, эсхүл үзүүлэх эсэх;

39.2.2.Монгол Улсын хууль тогтоомж, нийтийн ашиг сонирхолд нийцэж байгаа эсэх;

39.2.3.асуудлын шинж чанар, тухайн асуудал Монгол Улсын хувьд ач холбогдолтой эсэх;

39.2.4.мэдээлэл бэлтгэхтэй холбогдон зайлшгүй гарах зардлыг гадаадын зохицуулах байгууллага төлсөн эсэх;

39.2.5.энэ хуулийн 47 дугаар зүйлд заасны дагуу мэдээллийн нууцлалыг хангаж чадах эсэх.

39.3.Хороо гадаадын зохицуулах байгууллагын хүссэн мэдээлэлтэй холбогдуулж тодруулга ирүүлэхийг уг байгууллагаас хүсэж болно.

39.4.Гадаадын зохицуулах байгууллага нь энэ хуулийн 39.3-т заасан хүсэлтэд хариу ирүүлээгүй бол Хороо түүнд туслалцаа үзүүлэхээс татгалзаж болно.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ

АЛБАДЛАГА

40 дүгээр зүйл.Албадлагын арга хэмжээ авах үндэслэл

40.1.Хороо дараах үндэслэлээр даатгалын зуучлагчид албадлагын арга хэмжээ авч болно:

40.1.1.энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомж, даатгалын журмыг зөрчсөн;

40.1.2.үйлчлүүлэгчийн болон нийтийн ашиг сонирхолд, даатгалын төлөөлөгчийн хувьд даатгагчийн ашиг сонирхолд хохирол учруулахуйц нөхцөл байдал үүссэн;

40.1.3.энэ хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу Хорооноос өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

40.1.4.зөвшөөрөл олгох нөхцөл, шаардлагыг зөрчсөн;

40.1.5.зөвшөөрөл эзэмшигч, түүний удирдах албан тушаалтан, компанийн энгийн хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг дангаараа буюу бусад этгээдтэй хамтран эзэмшиж буй этгээд нь тус тус тохиромжтой бус этгээд гэж үзсэн;

40.1.6.энэ хуулийн 8.1-д заасан даатгалын брокер, 9.1-д заасан банк-зуучлагч болон 18.2.2-т заасан хэд хэдэн даатгагчийг төлөөлөх даатгалын төлөөлөгч татан буугдах хүсэлт гаргасан;

40.1.7.Хороонд бодитой бус, төөрөгдүүлсэн мэдээлэл өгсөн нь тогтоогдсон;

40.1.8.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангаа хууль тогтоомжид нийцүүлж хөтлөөгүй, тайлагнаагүй;

40.1.9.даатгалын зуучлалын үйл ажиллагааг зохих журмын дагуу явуулаагүй;

40.1.10.хамаарал бүхий этгээдийн үйл ажиллагааг шалгах явцад Хороотой хамтран ажиллахаас татгалзсан;

40.1.11.хууль тогтоомжид заасан бусад үндэслэл.

41 дүгээр зүйл.Албадлагын арга хэмжээний төрөл

41.1.Хороо энэ хуулийн 40.1-д заасан үндэслэлээр дараах төрлийн албадлагын арга хэмжээг хэрэглэнэ:

41.1.1.энэ хуулийн 8.1 болон 9.1-д заасан үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлэх;

41.1.2.энэ хуулийн 8.1 болон 9.1-д заасан үйл ажиллагааны зөвшөөрлийг хүчингүй болгох;

41.1.3.даатгалын төлөөлөгчийн эрхийг хасах;

41.1.4.энэ хуулийн 45 дугаар зүйлд заасны дагуу даалгавар өгөх;

41.1.5.энэ хуулийн 46 дугаар зүйлд заасны дагуу шалгагч томилох;

41.1.6.даатгалын зуучлалын үйл ажиллагааг зохистой явуулах талаар зөвлөх үүрэг бүхий дадлага туршлагатай мэргэжилтэн томилох.

42 дугаар зүйл.Зөвшөөрлийг түдгэлзүүлэх

42.1.Хороо зөвшөөрлийг дараах үндэслэлээр түдгэлзүүлнэ:

42.1.1.энэ хуулийн 40.1-д заасан үндэслэлийн аль нэг нь илэрсэн;

42.1.2.зөвшөөрлийн жил бүрийн төлбөрийг төлөх хугацаа өнгөрснөөс хойш 2 сарын дотор төлөөгүй.

42.2.Зөвшөөрлийг дараах хугацаагаар түдгэлзүүлнэ:

42.2.1.Хорооноос тогтоосон хугацаагаар;

42.2.2.Хорооноос тавьсан шаардлага, өгсөн даалгаврыг биелүүлэх хүртэл.

42.3.Энэ хуулийн 42.2.1-д заасан хугацаа нь 6 сараас хэтрэхгүй.

42.4.Зөвшөөрлийг түдгэлзүүлэхээс өмнө Хороо Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан сонсох ажиллагаа явуулна.

42.5.Зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 42.4-т заасан сонсох ажиллагааны мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд бичгээр, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан цахим хэлбэрээр ирүүлээгүй бол зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.

42.6.Зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тохиолдолд дараах агуулга бүхий мэдэгдлийг зөвшөөрөл эзэмшигчид бичгээр, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан цахим хэлбэрээр хүргүүлнэ:

- 42.6.1.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай;
- 42.6.2.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн үндэслэл;
- 42.6.3.зөвшөөрлийг түдгэлзүүлж эхэлсэн огноо;
- 42.6.4.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаа.

43 дугаар зүйл.Зөвшөөрлийг хүчингүй болгох, сэргээх

43.1.Хороо дараах үндэслэлээр зөвшөөрлийг хүчингүй болгоно:

- 43.1.1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;
- 43.1.2.зөвшөөрөл эзэмшигч татан буугдсан, эсхүл дампуурсан;
- 43.1.3.зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 43.1.4.зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;
- 43.1.5.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;
- 43.1.6.зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын дотор үйл ажиллагаагаа эхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон;
- 43.1.7.хуульд заасан бусад.

43.2.Зөвшөөрлийг хүчингүй болгохоос өмнө Хороо Захиргааны ерөнхий хуулийн 27 дугаар зүйлд заасан сонсох ажиллагааг явуулна.

43.3.Зөвшөөрөл эзэмшигч энэ хуулийн 43.2-т заасан сонсох ажиллагааны мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор зөвшөөрлийг нь хүчингүй болгох үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд бичгээр, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан цахим хэлбэрээр ирүүлээгүй бол зөвшөөрлийг хүчингүй болгоно.

43.4.Зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд дараах агуулга бүхий мэдэгдлийг зөвшөөрөл эзэмшигчид бичгээр, эсхүл энэ хуулийн 10.2-т заасан цахим хэлбэрээр хүргүүлнэ:

- 43.4.1.зөвшөөрлийг хүчингүй болгосон тухай;
- 43.4.2.зөвшөөрлийг хүчингүй болгосон үндэслэл;
- 43.4.3.зөвшөөрлийг хүчингүй болгосон огноо.

43.5.Зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш 3 жилийн дараа тухайн этгээд дахин зөвшөөрөл авахаар хүсэлт гаргах эрхтэй.

44 дүгээр зүйл.Даатгалын төлөөлөгчийн эрхийг хасах, сэргээх

44.1.Хороо дараах үндэслэлээр даатгалын төлөөлөгчийн эрхийг хасна:

- 44.1.1.даатгалын төлөөлөгч хүсэлт гаргасан;
- 44.1.2.даатгагч хүсэлт гаргасан;
- 44.1.3.эрх авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;
- 44.1.4.даатгалын төлөөлөгч нас барсан;
- 44.1.5.даатгалын журмыг 2 удаа зөрчсөн.

44.2.Эрхийг хасахаас өмнө Хороо эрхийг хасах болсон үндэслэлийг заасан мэдэгдлийг даатгагчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлж, хүргэсэн огноог тэмдэглэнэ.

44.3.Даатгагч уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш ажлын 14 өдрийн дотор эрхийг хасах нь үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбараа Хороонд ирүүлээгүй бол эрхийг хасна.

44.4.Эрхийг хассан тохиолдолд дараах агуулга бүхий мэдэгдлийг даатгагчид бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүргүүлнэ:

- 44.4.1.эрхийг хассан тухай;
- 44.4.2.эрхийг хассан үндэслэл;
- 44.4.3.эрхийг хассан огноо.

44.5.Хороо эрхийг хассан тухай даатгалын журамд заасны дагуу нийтэд мэдээлнэ.

44.6.Эрхийг хассанаас хойш 1 жилийн дараа тухайн этгээд даатгалын төлөөлөгчийн эрх авах хүсэлт гаргах эрхтэй.

45 дугаар зүйл.Даалгавар

45.1.Хороо даатгалын зуучлагчид албадлагын арга хэмжээ авахдаа дараах агуулга бүхий даалгаврыг улсын байцаагчийн албан шаардлагаар өгч болно:

45.1.1.даатгалын зуучлалын тодорхой хэлбэр, төрлийн үйл ажиллагаа эрхлэхийг түр зогсоох;

45.1.2.тодорхой хэлбэр, төрлийн үйл ажиллагаатай холбоотой шинээр гэрээ байгуулахыг хориглох;

45.1.3.байгуулсан даатгалын гэрээг өөрчлөхийг хориглох;

45.1.4.шаардлагатай мэдээлэл, баримт бичгийг энэ хууль, бусад хууль тогтоомж, даатгалын журамд зааснаас богино хугацаанд гаргаж өгөх.

45.2.Энэ хуулийн 45.1-д заасны дагуу Хорооноос өгч буй аливаа даалгаврыг даатгалын зуучлагч биелүүлэх үүрэгтэй.

45.3.Энэ хуулийн 45 дугаар зүйл зөвшөөрлийг нь түдгэлзүүлсэн болон хүчингүй болгосон, эрхийг хассан этгээдэд нэгэн адил хамаарна.

46 дугаар зүйл.Шалгагчийг томилох

46.1.Хороо энэ хуулийн 40.1-д заасан үндэслэлээр албадлагын арга хэмжээ авахдаа тухайн этгээдийн үйл ажиллагааг хянан шалгах үүрэг бүхий нэг буюу хэд хэдэн этгээдийг шалгагчаар томилж болно.

46.2.Энэ хуулийн 46.1-д заасны дагуу томилогдсон шалгагч нь дараах асуудлыг хянан шалгаж болно:

46.2.1.тухайн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, шинж байдал;

46.2.2.тухайн этгээдийн үйл ажиллагааны тодорхой асуудал;

46.2.3.тухайн этгээдийн болон хувьцаа эзэмшигчдийн хяналт.

46.3.Шалгагч нь шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдийн үйл ажиллагаа болон компанийн нэгдлийн бусад гишүүдийн үйл ажиллагааг хэдийд ч шалгаж болно.

46.4.Шалгагчийн томилолтын хугацаа болон нөхцөлийг Хороо тогтооно.

АРАВДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

47 дугаар зүйл.Мэдээллийн нууцлалыг хадгалах

47.1.Хороо болон холбогдох бусад байгууллага, албан тушаалтан нь энэ хууль болон бусад хууль тогтоомжид заасан өөрийн бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараах этгээдтэй холбоотой аливаа мэдээллийг бусдад задруулахыг хориглоно:

47.1.1.зөвшөөрөл авах, эрх авах хүсэлт гаргасан этгээд;

47.1.2.даатгалын зуучлагч, эсхүл даатгалын зуучлагч байсан этгээд, тэдгээрийн хараат болон охин компани;

47.1.3.даатгуулагч, эсхүл даатгуулагч байсан этгээд.

47.2.Дараах тохиолдолд энэ хуулийн 47.1 дэх хэсэг хамаарахгүй:

47.2.1.тухайн этгээд өөрийн нууцыг задруулахыг бичгээр зөвшөөрсөн;

47.2.2.шүүх болон прокурор, цагдаа, тагнуул, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажлын шаардлагаар тэдгээр байгууллагын удирдлага хүсэлт гаргасан;

47.2.3.энэ хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор тухайн этгээд мэдэх шаардлагатай;

47.2.4.уг мэдээллийг олон нийт бусад эх сурвалжаас мэдэх боломжтой, эсхүл нэгэнт мэдээлэгдсэн;

47.2.5.тухайн мэдээлэлтэй холбогдох энэ хуулийн 47.1-д заасан этгээдийг таних боломжгүй байдлаар буюу мэдээллийг товчлол, эсхүл статистик тоо баримтаар мэдээлэх;

47.2.6.энэ хуулийн 39.1-д заасны дагуу гадаадын зохицуулах байгууллага бичгээр, эсхүл цахим хэлбэрээр хүсэлт гаргасан.

48 дугаар зүйл.Даатгалын зуучлагчид гомдол гаргах

48.1.Даатгуулагч нь аливаа даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбоотой хууль болон гэрээгээр олгогдсон өөрийн эрх ашиг зөрчигдсэн гэж үзвэл даатгалын зуучлагчид амаар, утсаар, бичгээр, цахим шуудан болон цахим хуудас зэргээр гомдол гаргана.

48.2.Даатгалын зуучлагч нь даатгуулагчийн гаргасан гомдлыг хүлээн авч бүртгэснээс хойш шууд шийдвэрлэх боломжтой тохиолдолд ажлын гурав хүртэл өдөр, бусад гомдлыг 30 хүртэл өдрийн дотор шийдвэрлэж, хариуг мэдэгдэнэ.

48.3.Гомдол шийдвэрлэсэн шийдвэрийг даатгуулагч эс зөвшөөрсөн тохиолдолд Хороонд гомдол гаргах эрхтэй талаар даатгалын зуучлагч нь даатгуулагчид мэдэгдэх үүрэгтэй.

48.4.Даатгуулагч нь даатгалын зуучлагчийн гаргасан шийдвэрийг эс зөвшөөрсөн, эсхүл гомдлыг шийдвэрлээгүй тохиолдолд гомдол шийдвэрлэх хугацаа дууссанаас хойш таван сарын дотор Хороонд гомдол гаргаж болно.

48.5.Даатгуулагчаас даатгалын зуучлагчид гаргасан гомдлыг Даатгалын тухай хуульд заасны дагуу шийдвэрлэнэ.

49 дүгээр зүйл.Маргаан шийдвэрлэх

49.1.Аливаа этгээд даатгалын зуучлагчийн үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг Хороонд тавьж шийдвэрлүүлэх бөгөөд Хороо түүнийг урьдчилан шийдвэрлэнэ.

50 дугаар зүйл.Маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх

50.1.Арбитрын хэлэлцээртэй бол даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбогдон гарсан маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.

50.2.Энэ хуулийн 50.1-д заасны дагуу маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх тохиолдолд энэ хуулийн 49 дүгээр зүйл хамаарахгүй.

51 дүгээр зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

51.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

51.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

52 дугаар зүйл.Хорооны албан хаагчийн хязгаарлагдмал хариуцлага

52.1.Хорооны албан хаагч энэ хууль, холбогдох бусад хууль болон даатгалын журамд заасан үүргээ шударга бусаар хэрэгжүүлсэн буюу санаатайгаар хэрэгжүүлээгүй болох нь тогтоогдсоноос бусад тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

53 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

53.1.Энэ хуулийг 20... оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ХУУЛЬ ХУЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. 2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр баталсан Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын зуучлалын тухай /Шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.2.4 дэх заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь заалтын “мэргэжлийн оролцогчийн” гэснийг “зуучлалын” гэж, 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “зуучлагч” гэснийг “брокер”, “хохирол үнэлэгчийн” гэснийг “банк-зуучлагчийн” гэж, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийн “8, 9, 10, 11, 12, 38, 39 дүгээр зүйлд” гэснийг “9, 10, 11, 12, 13, 14, 18, 19, 20, 21, 42, 43, 44 дүгээр зүйлд” гэж, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийн “30, 31, 32, 33, 34 дүгээр зүйлд” гэснийг “34, 35, 36, 37, 38 дугаар зүйлд” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтын “хохирол үнэлэгчийн” гэснийг хассугай.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын зуучлалын /шинэчилсэн найруулга/ тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 11.14 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай.

“9.Аливаа этгээд Даатгалын зуучлалын тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй, эсхүл хориглосон хэм хэмжээг зөрчсөн, эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм, журам, заавар, аргачлалыг дагаж мөрдөөгүй, биелүүлээгүй, эсхүл нөхөн төлбөрийн хэмжээг тогтооход шаардлагатай мэдээллийг даатгагчийн шаардсан хугацаанд гаргаж өгөөгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 11.14 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 1, 8, 9 дэх хэсгийн “мэргэжлийн оролцогчийн” гэснийг “зуучлалын” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “Тусгай зөвшөөрөлгүйгээр” гэснийг “Зөвшөөрөлгүйгээр” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийг” гэснийг “зуучлагчийг” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “зуучлагч, даатгалын хохирол үнэлэгчийн” гэснийг “зуучлагчийн” гэж, мөн зүйлийн 4, 6, 8 дахь хэсгийн “мэргэжлийн оролцогч” гэснийг “зуучлагч” гэж, мөн зүйлийн 7 дахь хэсгийн “хоногийн” гэснийг “өдрийн” гэж тус тус өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 11.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “, даатгалын хохирол үнэлэгч” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Даатгалын зуучлалын /шинэчилсэн найруулга/ тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

МӨНГӨ УГААХ БОЛОН ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХТЭЙ
ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “даатгалын мэргэжлийн оролцогч” гэснийг “даатгалын зуучлагч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын зуучлалын /шинэчилсэн найруулга/ тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

МАЛЫН ИНДЕКСЖҮҮЛСЭН ДААТГАЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Малын индексжүүлсэн даатгалын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “даатгалын мэргэжлийн оролцогчийн” гэснийг “даатгалын зуучлалын” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын зуучлалын /шинэчилсэн найруулга/ тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.3 дахь заалтын “даатгалын зуучлагч” гэснийг “банк-зуучлагч” гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Даатгалын зуучлалын /шинэчилсэн найруулга/ тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ2024 оны ... дугаар
сарын ... -ны өдөрУлаанбаатар
хот

1 дүгээр зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт доор дурдсан агуулгатай заалтыг нэмсүгэй.

1/ Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:

2.39. Банк-зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
---	-----------------------------

2/ Зөвшөөрлийн тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

2.53. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх	Санхүүгийн зохицуулах хороо
2.54. Гадаадын даатгалын брокер Монгол Улсад салбар, төлөөлөгчийн газар нээх	Санхүүгийн зохицуулах хороо

2 дугаар зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.14 дахь заалтын “зуучлагчийн” гэснийг “брокерын” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Зөвшөөрлийн тухай хуулийн 8.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2.13, 2.15 дахь заалтыг тус тус хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Даатгалын зуучлалын тухай /шинэчилсэн найруулга/ хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ